



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Г “Грийт секьюритис” ХХК-д 7
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Грийт секьюритис” ХХК-д үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Грийт секьюритис” ХХК /Б.Өлзийбаяр/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дүгэржав/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН